

4

ГАДААД ХУДАЛДААНЫ СТАТИСТИК СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Э.Гүргэмжав, А.Дэмбэрэл

Нэг. Гадаад худалдааны статистик судалгааны одоогийн арга зүй

Гадаад худалдааны статистик мэдээлэл гаргах аргачлалын талаар. Гадаад худалдааны үр ашгийг зөв тооцох хамгийн гол үндэс бол гадаад худалдааны статистик мэдээллийг гаргах аргачлалаас шалтгаална.

Гадаад худалдааны статистикийг 1993 оноос өмнөх хугацаанд экспорт, импортын үйл ажиллагаа явуулсан үйлдвэр, аж ахуйн газрууд үйл ажиллагааныхаа талаархи статистикийн тайлан мэдээг гадаад худалдааны байгууллагад өгч, эдгээр мэдээг Гадаад худалдааны яам нэгтгэн Статистикийн төв байгууллагад дамжуулан өгөх журмаар гаргаж байсан.

1990 оноос гадаад худалдааны салбарт оролцогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тоо эрс нэмэгдсэнээр гадаад худалдааны статистик мэдээллийг бүртгэх, цуглуулах хуучин аргыг ашиглах боломжгүй болсон юм. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд нэгдсэн аргачлалаар гадаад худалдааны статистик мэдээллийг гаргадаг байсан.

Харин 1995 оноос эхэлж гадаад худалдааны статистикийг олон улсын жишигт нийцүүлж "Гадаад худалдааны гаалийн статистикийн аргачлал"-ыг Монгол Улсын Статистикийн Төв Газар, Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газраас шинээр боловсруулан баталж гаргасан бөгөөд 1997 онд уг аргачлалыг шинэчлэн сайжруулж мөрдсөн. 1998 онд НҮБ-ын Эдийн Засаг, Нийгмийн Зөвлөлийн Статистикийн Хэлтэс "Гадаад худалдааны үндсэн зарчим, тодорхойлолт" гэсэн аргачлал,

зөвлөмжийг гаргаж гишүүн орнууддаа мөрдөхийг санал болгосон юм. Энэхүү аргачлал, зөвлөмжийг үндэслэж ҮСГ, ГЕГ хамтран "Монгол улсын гадаад худалдааны бараа эргэлтийн гаалийн статистик мэдээллийг эмхлэн гаргах аргачлал"-ыг дахин шинэчлэн боловсруулж гадаад худалдааны статистикт 2002 оноос мөрдөж ажиллаж байгаа.

Гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл гаргах аргачлал болон ОУВС-аас гаргасан Төлбөрийн тэнцлийн аргачлалын дагуу Монголбанкны аж ахуйн нэгжүүдээс худалдан авч, гадаадад гаргаж цэвэршүүлж, гадаадын банкинд хадгалуулдаг алтнаас банкны бус байгууллага, аж ахуйн нэгжид зарсан арилжааны зориулалттай мөнгөжөөгүй алтыг 2002 оны 10 сараас гадаад худалдааны статистик мэдээнд тусган тооцдог болов.

Гадаад худалдааны гаалийн статистик мэдээллийг гаргах үндсэн бүртгэл нь гаалийн хилээр нэвтрүүлсэн барааны талаархи хэрэгцээтэй бүх мэдээллийг агуулсан гаалийн мэдүүлэг бөгөөд гаалийн бүрдүүлэлт хийсэн эцсийн өдрөөр экспорт, импортыг бүртгэж статистикийн албан ёсны мэдээнд тусгаж байна.

Барааны бүлэг, нэр төрлийг Дэлхийн Худалдааны Байгууллагаас боловсруулсан "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн ангилалын дагуу гаргаж байна.

Албан ёсны статистикийн тайланд экспорт, импортын нийт хэмжээг дараахи бүлгээр үзүүлж байна. Үүнд:

- валютын төлбөрт худалдаа
- бараа солилцоо
- төлбөрт зориулсан бараа
- гадаадын захиалагчийн материал, түүгээр хийсэн бараа
- гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа
- гадаадын тусламжийн бараа
- хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа

Экспортын барааг ДАФ – Монгол улсын хил нөхцлийн үнээр тооцдог. Импортын барааг Монгол улсын хил хүртэлх бүх зардлыг шингээсэн СИП-Монгол улсын хил нөхцлийн үнээр үнэлж статистикт бүртгэж байна. Экспорт, импортын барааны үнийг америк долларт шилжүүлэхдээ гаалийн анхны болон эцсийн бүрдүүлэлт хийсэн өдрийн Монгол банкны валютын ханшийг хэрэглэж байна.

Гадаад худалдааны статистик судалгааны одоогийн аргачлал. Гадаад худалдааны үр ашгийн статистик судалгааг гадаад худалдааны үнийн болон тоо хэмжээний индексийн тооцоон дээр тулгуурлан хийж байна. Эдгээр индексийг тооцохдоо Гаалийн Ерөнхий Газрын жилийн эцсийн экспорт, импортын дэлгэрэнгүй нэр төрлийг ашигладаг.

Гадаад худалдааны үр ашгийн тооцоо, судалгаа хийх гол зорилго нь гадаад худалдааны ашиг алдагдал, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхойлох явдал юм. Ийм судалгаанд экспорт, импортын гол нэрийн бараануудын нэгжийн дундаж үнийн болон тоо хэмжээний өөрчлөлтийг харуулж, экспорт, импортын барааны дундаж үнэ, тоо хэмжээ өөрчлөгдсөнөөс хэдий хэмжээний валютын орлого олох боломжийг алдсаныг харуулж байгаа юм.

Үүнээс гадна гадаад худалдааны гол нэрийн барааны нэгжийн дундаж үнийг худалдааны түнш орнуудаар харуулж, тухайн барааг аль оронд хамгийн өндөр буюу бага үнээр худалдав, аль орноос хамгийн өндөр буюу хамгийн бага үнээр худалдан авав, тухайн оронд худалдсан буюу тухайн орноос худалдан авсан барааны үнэ өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөн зэргийг харуулна.

Түүнчлэн гадаад худалдааны үнэ, тоо хэмжээний ерөнхий индекс болон тэдгээрийн харьцаа, худалдааны нөхцлийн коэффициентийг тооцдог.

Эдгээр асуудлуудыг судлан тодорхой санал, арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд гадаад худалдааны үнийн болон тоо хэмжээний өөрчлөлтийн талаархи судалгааны материалын ач холбогдол оршино.

Үнийн индекс тооцох талаар. Гадаад худалдааны үр ашгийг тооцох хамгийн гол арга бол экспорт, импортын үнийн болон тоо хэмжээний индексийн тооцоо юм. Үндэсний Статистикийн газраас НҮБ-ын Статистикийн хэлтсээс боловсруулж гаргасан гишүүн орнуудад хэрэглэхийг зөвлөмж болгосон "Олон Улсын худалдаанд хэрэглэж байгаа үнийн индексийн аргачлал"-д нийцүүлэн 1997 онд баталсан "Монгол Улсад гадаад худалдааны үнийн болон тоо хэмжээний индекс тооцох аргачлал"-ын дагуу экспорт, импортын үнийн болон биет хэмжээний индексийн тооцоог хийж байгаа болно.

Гадаад худалдааны үнийн индексийн үзүүлэлт нь худалдааны судалгаа, шинжилгээ, мэдээллийн ажлыг зах зээлийн эдийн засгийн утга агуулгаар баяжуулж, худалдааны үйл ажиллагаа, гадаад

худалдааны үр ашиг, нөхцлийг бодитой үнэлж дүгнэх, түүний үзүүлэлтүүдийн тооцооны үндэслэлийг сайжруулахын зэрэгцээ дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоог боловсронгуй болгох, үндэсний тооцооны дансуудыг байгуулахад ордог шаардлагатай зарим үзүүлэлтийг тооцоход ашиглагдаж байна.

Үнийн индексийн тооцооны ажлын чанар нь гаалийн статистикийн экспорт, импортын барааны нэр төрлийн тоо, үнийн үнэн зөв байдал, мэдээнд тусгагдаж байгаа барааны бүлэг, дэд бүлгийн бүтцээс шууд хамаарч байна.

Улсын хилээр орсон, гарсан барааны урсгал хөдөлгөөнийг бүртгэдэг гаалийн мэдүүлэг нь үнийн индексийг тооцох эх үүсвэр, анхдагч баримт болно. Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газар ГАМАС программаар мэдээллийг нэгтгэн боловсруулж "экспорт импортын барааны гүйцэтгэл" гэсэн статистикийн албан ёсны мэдээллийг сар бүр гаргадаг бөгөөд энэхүү мэдээлэлд тусгагдсан барааны нэр төрлөөр бараа тус бүрийн дундаж үнийг тооцож үнийн индексийг тооцдог.

Олон улсын худалдаанд мөрдөж байгаа "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем" – ийн ангиллын дагуу экспорт, импортын барааны нэр төрөл, бүлэг, хэсгийн үнийн индексийг тодорхойлох бөгөөд 4, 6, 8 оронтой цифрээр кодлогдсон барааны нэр төрлөөр төлөөлөгч барааг сонгож байна.

Барааны сагсыг 3 жил тутам дахин хянан үзэж, шаардлагатай бол түүнийг өөрчлөн тогтоох бөгөөд сагсанд орсон бараа худалдаанаас хасагдсан тохиолдолд түүнийг ижил төрлийн өөр бараагаар орлуулж, нэгжийн үнийн динамикийг тухай бүрд нь засварлах учиртай.

Сонгож авсан бараа нь олон нэр төрлөөс бүрдэж байвал аль болох нэг нэр төрлийн, шинж чанарын хувьд ижил төстэй, нэгжийн үнэ нь онцын их ялгаатай бус байх шаардлагатай.

Экспортлосон буюу импортлосон барааны нийт үнэ (өртөг) нь биет хэмжээг түүний нэгжийн үнээр үржүүлсэнтэй тэнцүү. Үүнийг томъёонд оруулбал:

$$V_{nt} = p_{nt}q_{nt} (1)$$

V_{nt} - үнэ (үнийн дүн буюу өртөг)

p – барааны нэр төрөл

t – тайлант үе

p_{nt} - p нэр төрлийн барааны үнэ, тайлант үе

q_{nt} – n нэр төрлийн барааны бие хэмжээ, тайлант үе

Эдийн засгийн статистикт гол төлөв 2 тооны харьцааг индекс гэж нэрлэх бөгөөд тайлант хугацаанд экспортлосон буюу импортлосон барааны үнийн дүнг суурь үеийнхтэй харьцуулсан индекс дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$V_i = v_{nt}/v_{no} \quad (2)$$

i – индекс o – суурь үнэ

Энэ томъёогоор (2) өртгийн индекс тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл тухайн үеийнхээ үнээр илэрхийлэгдсэн харьцаа юм.

Томъёо 1-ийг үндэслэж, өртгийн индексийг үнийн болон бие хэмжээний индексээр илэрхийлж болно. Үүнийг үзүүлвэл:

$$p_i = p_{nt}/p_{no} \text{ ба } q_i = q_{nt}/q_{no} \quad (3)$$

Энд p_i – n барааны хувийн индекс, q_i – n барааны бие хэмжээний индекс p_{nt} буюу q_{nt} – n барааны тайлант үеийн үнэ болон биет хэмжээ бөгөөд өртгийн индексийн томъёог (2)-г дараах байдлаар илэрхийлж болно.

$$\text{Үүнд: } v_i = p_{nt} q_{nt} / p_{no} q_{no} = p_i \cdot q_i \quad (4)$$

Томъёо 4-өөс үзэхэд тайлант үеийн өртгийн хэмжээг суурь үеийн өртгийн хэмжээнд харьцуулсан харьцааг өртгийн индекс гэнэ. Өртгийн индекст нөлөөлж байгаа тоо, хэмжээний нөлөөллийг арилгаж, зөвхөн үнийн өөрчлөлтийг харуулахын тулд үнийн индексийг тооцох шаардлага гардаг.

Олон улсын практикт үнийн индексийн 3 хэлбэр (арга) байна. Үүнд: Ласпейресийн, Паашегийн, Фишерийн гэсэн 3 хэлбэрийн индекс байгаа юм. Ихэнх орнууд Ласпейресийн аргаар үнийн индексийг тодорхойлж байгаа бөгөөд НҮБ-ын статистикийн ажлын практикт ч индексийн энэ хэлбэрийг хэрэглэж байна.

Үнийн индекс тооцох Ласпейресийн болон Паашегийн томъёог үзүүлье:

$$PIL = \frac{\sum p_{nt} q_{no}}{\sum p_{no} q_{no}} \quad (5)$$

$$PIP = \frac{\sum p_{nt} q_{nt}}{\sum p_{no} q_{nt}} \quad (6)$$

PIL – үнийн индекс Ласпейрес гэсэн үгийн эхний үсгүүд, англиар
PIP – үнийн индекс Пааше гэсэн үгийн эхний үсгүүд, англиар

Судалгааны зорилгоос хамаарч энэ 2 индексийн алийг нь ч ашиглаж болно. Олон улсын статистикийн ажлын практикт үндэсний тооцооны зарим үзүүлэлтийг зэрэгцүүлэх үнээр үнэлэх, дотоодын нийт бүтээгдэхүүний дефлятор, экспорт, импортын барааны үнийн индексийг тооцоход Ласпейресийн томъёог хэрэглэдэг.

Олон улсын хэмжээнд мөрдөж байгаа аргачлалын дагуу бараа тус бүрийн экспорт, импортын нийт дүнд эзлэх хувийг индексийн жин болгон авч үнийн ерөнхий болон бүлгийн индексийг тооцно. Экспорт, импортын нийт дүнд бараа тус бүрийн эзлэх хувийг дараах томъёогоор тооцно.

$$W_{no} = \frac{P_{no} q_{no}}{\sum p_{no} q_{no}} \quad (7)$$

Томъёо 7 нь суурь үеийн бараа тус бүрийн үнийн дүнг мөн үеийн экспорт, импортын нийт дүнд харьцуулсан харьцаа болно. Үүнийг тооцохдоо тэг бүхлийн ард 5 орны нарийвчлалтай авна. Жишээлбэл: 0.00001 гэсэн хэлбэртэй байна. Зарим барааны нийт дүнд эзлэх хувь маш бага байдаг бөгөөд түүнийг тооцоонд хамруулахын тулд 5 орны нарийвчлалтай авч байгаа юм.

Бараа тус бүрийн тайлант үеийн үнийг индекс ашиглан дараах байдлаар ($p_{nt} = p_{it} \cdot p_{no}$) илэрхийлж, үүнийг Ласпейресийн үнийн индексийн томъёонд оруулъя.

$$PIL = \frac{\sum p_{nt} q_{no}}{\sum p_{no} q_{no}} = \frac{\sum p_{it} p_{no} q_{no}}{\sum p_{no} q_{no}} = \sum p_{it} \frac{p_{no} q_{no}}{\sum p_{no} q_{no}} \quad (8)$$

буюу

$$PIL = \sum p_{it} w_{no} \quad (9)$$

$$\text{Эндээс: } PIL = \frac{\sum p_{nt} w_{no}}{\sum p_{no} w_{no}} \quad \text{буюу} \quad PIL = \frac{\sum p_{it} w_{no}}{\sum w_{no}} \quad (10)$$

Томъёо 10 бол экспорт, импортын үнийн ерөнхий болон бүлгийн индексийг тооцох томъёо болно

Экспорт, импортын гүйцэтгэлийг тогтмол үнээр (зэрэгцүүлэх) үнэлэхдээ өртгийн индексийг үнийн индексэд хувааж гаргана. Үүнийг дараах томъёогоор илэрхийлнэ. Үүнд:

$$p_{nt} q_{nt} : \frac{p_{nt}}{p_{no}} = \frac{p_{nt} q_{nt} p_{no}}{p_{nt}} = p_{no} q_{nt} \quad (11)$$

$p_{no} q_{nt}$ - экспорт, импортын тайлант үеийн бие хэмжээг суурь үеийн үнээр үнэлсэн,

Экспорт, импортын өртгийн индексийг Паашегийн үнийн индекс хувааж, экспорт, импортын бие хэмжээний индексийг тодорхойлно. Үүнийг томъёогоор үзүүлбэл:

$$\frac{VI}{PIL} = \frac{\sum p_{nt} q_{nt}}{\sum p_{no} q_{no}} : \frac{\sum p_{nt} q_{nt}}{\sum p_{no} q_{nt}} = \frac{\sum p_{no} q_{nt}}{\sum p_{no} q_{no}} = QIP$$

QIP- Паашегийн биет хэмжээний индекс гэсэн үгийн эхний үсгүүд, англиар

Экспорт, импортын барааны үнийн индексийг үнийн ерөнхий индекс, барааний бүлгийн үнийн индекс, барааны нэгжийн үнийн индекс гэж ангилна.

Үнийн ерөнхий индекс гэдэг нь экспорт, импортын барааны нийт дүнгээр тооцож гарах индексийг ерөнхий индекс, барааны бүлэг тус бүрээр тодорхойлогдох индексийг бүлгийн индекс гэнэ. Тухайлбал, "Барааг кодлох, тодорхойлох уялдуулсан систем" – ийн 21 бүлэг тус бүрээр үнийн индекс тооцно. Барааны нэр төрлийн нэгжийн (кг, литр, ширхэг зэрэг) тайлант буюу суурь үеийн үнийн харьцааг барааны нэгжийн үнийн индекс гэнэ.

Мөн түүнчлэн гадаад худалдааны гол хэлбэрүүдээр, тухайлбал, валютын төлбөрт худалдаа, бараа солилцоо, зээлийн бараа, тусламжийн бараа, хөрөнгө оруулалтын бараа, гадаадын захиалагчийн материал зэрэг худалдааны хэлбэр бүрээр үнийн индексийг тодорхойлж болно.

Гаалийн статистикийн мэдээнд тусгагдаж байгаа экспорт, импортын барааны нэгжийн үнийг хилийн үнэ гэх бөгөөд үнийн индексийг хилийн дундаж үнийн индекс гэж нэрлэдэг.

Худалдааны нөхцлийг тооцож судалгаа дүгнэлт хийх талаар. Гадаад худалдааны төлөв байдал, хандлагад үнэлэлт, дүгнэлт өгөхөд худалдааны нөхцлийг тооцох явдал ихээхэн ач холбогдолтой юм.

Экспортын дундаж үнийн индексийг импортын дундаж үнийн индекс харьцуулсан харьцааг худалдааны нөхцөл гэж нэрлэдэг бөгөөд энэ харьцаа 1-ээс дээш гарвал худалдааны нөхцөл тааламжтай байна гэж үздэг.

$$TOT = \frac{Lpx}{Lpi} * 100\%$$

TOT- худалдааны нөхцлийн индекс (terms of trade)

Lpx- экспортын Ласпейресийн үнийн индекс

Lpi- импортын Ласпейресийн үнийн индекс

Мөн ямар нэгэн суурь онтой харьцуулан өөрчлөгдсөн хэмжээгээр нь худалдаа хэр сайжирсан болон буурсан болохыг хэмждэг билээ. Өөрөөр хэлбэл худалдааны нөхцлийн индексийг 2 янзаар тайлбарладаг байна. Үүнд:

1. Индекс 1 буюу 100 хувиас илүү тохиолдолд тайлант үеийн худалдааны нөхцөл нь суурь болгож авсан үетэй харьцуулахад илүү тааламжтай байсан байна гэж үзнэ. Өөрөөр хэлбэл суурь үетэй харьцуулсан экспортын жигнэсэн дундаж үнийн өсөлт импортын жигнэсэн дундаж үнийн өсөлтөөс илүү байгаа нөхцөлд индекс 1 буюу 100 хувиас давж гардаг байна. Импортын үнэ хямдрах нь экспортын үнэ өсөхтэй ижил нөлөөлөл үзүүлнэ. Жишээ нь 1999 оныг суурь болгосон манай улсын худалдааны нөхцөл 2000 онд 117.7 байсан гэвэл 2000 оны худалдааны нөхцөл 1999 оныг бодвол илүү тааламжтай нөхцөлд байсан гэж үзнэ. Учир нь 2000 онд экспортын үнэ импортын үнээсээ илүү хурдан өсч байв.

2. Худалдааны нөхцлийн суурь индексүүдийн өөрчлөлтийн хувийг тооцсноор худалдааны нөхцөл яаж өөрчлөгдснийг тодорхойлно. Тухайлбал харьцуулж буй 2 үеийн суурь индексүүд нь хоёулаа 100 хувиас илүү буюу суурь үетэй харьцуулахад худалдааны нөхцөл нь илүү тааламжтай байсан байж болно. Гэтэл өөрчлөлт нь сөрөг гарвал худалдааны нөхцөл муудаж байгааг гэрчилнэ. Жишээ нь 1999 оныг суурь болгосон манай улсын худалдааны нөхцөл 1997 онд 128.7, 1998 онд 107.3 байсан гэвэл 1998 оны худалдааны нөхцөл 1997 оныг бодвол 16.6 хувиар муудсан гэж үзнэ. Нөгөө талаас 1997

болон 1998 оны худалдааны нөхцлийг суурь үе буюу 1999 оныхтой харьцуулахад илүү тааламжтай байсан байна.

Манай орны гадаад худалдааны үнийн болон худалдааны нөхцлийн индексийн тооцоог сүүлийн 3 жилээр харуулъя.

	2001	2002	2003
Үнийн индекс;			
Экспорт	83.5	80.3	97.0
Импорт	139.2	130.8	142.0
Биет хэмжээний индекс;			
Экспорт	114.4	125.4	130.4
Импорт	117.4	129.1	150.3
Худалдааны нөхцлийн индекс	60.0	61.4	68.3

Уг хүснэгтээс харахад худалдааны нөхцлийн индекс 100 хувиас доогуур байгаа нь манай гадаад худалдаа маш тааламжгүй байдалд байна гэж үзэж болохоор байна. Экспортын үнэ нэмэгдэж, импортын үнэ буурснаар худалдааны нөхцөл сайжрах үндэс тавигдана. Томоохон орны хувьд импортыг орлуулах нь экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээс илүү таатай худалдааны нөхцлийг бий болгоод өгдөг. Импортыг дотоодын үйлдвэрлэлээр орлуулах нь импортын үнэд шууд буурах нөлөө үзүүлнэ.

Гэвч Монгол улсын хувьд дотоод үйлдвэрлэлийн өртөг болон чанар импортын бараатай өрсөлдөж чадахгүй байгаа нь импортын үнэд нөлөөлж чадахгүй байгаад хүргэж байна. Нөгөө талаас экспортын үнэд нөлөөлөх боломж Монгол шиг жижиг улсын хувьд мөн хүндрэлтэй асуудал юм. Эдийн засгийн хөгжлийн сул дорой байдлаас шалтгаалан манай улсын экспортын дийлэнхийг зэс, ноолуур, арьс шир гэх мэт түүхий эд бүрдүүлж байна. Үүнээс гадна түүхий эдийнхээ үнэд бодитой нөлөө үзүүлж чадахгүй учир дэлхийн зах зээлийн үнийн өөрчлөлт манай улсын худалдааны нөхцөлд хүчтэй нөлөөлж байгаа юм. Тиймээс түүхий эдээ эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулж илүү өндөр үнээр зарах нөхцөлд манай улсын худалдааны нөхцөл сайжрах боломжтой юм.

Хоёр. Гадаад худалдааны статистик судалгааны арга зүйг боловсронгуй болгох чиглэл

Гадаад худалдааны статистик мэдээллийг сайжруулах талаар. Үндэсний болон орон нутгийн аливаа шийдвэр гаргах бүхий л түвшинд албан ёсны статистик мэдээллээс гадна тодорхой

чиглэлээр хийгдсэн статистик судалгаа зайлшгүй хэрэгтэй. Гадаад худалдааны статистик судалгааны арга зүйг боловсронгуй болгох ажлыг нь юуны өмнө холбогдох мэдээллийн хамралт, чанарыг сайжруулахтай салшгүй холбоотой юм. Манай орны гадаад худалдааны статистик мэдээлэл нь олон улсын нийтлэг аргачлалын дагуу гарч байгаа гэж хэлж болох хэдий ч чанарыг цаашид илүү сайжруулах, хамрах хүрээг нэмэгдүүлэх шаардлагатай.

Гадаад худалдааны статистикийн мэдээлэл нь гаалийн мэдүүлэг дээр үндэслэгдэн гарч байгаа. Гадаад худалдаанд оролцогч аж ахуйн нэгж, иргэд нь барааг улсын хилээр нэвтрүүлэхдээ гаалийн байгууллагад мэдүүлж, гаалийн байгууллага нь бүрдүүлсэн мэдүүлгийн үндсэн дээр гаалийн гадаад худалдааны статистик мэдээллийг эрхлэн гаргаж байна.

Гаалийн байгууллага нь гадаад худалдааны мэдээллийг нэгтгэн боловсруулахдаа гаалийн мэдүүлгээс гадна мэдүүлгийн бус эх сурвалжуудыг ч хамруулдаг, тухайлбал цахилгаан эрчим хүчний импортын хэмжээг эрчим хүчний асуудал эрхэлсэн холбогдох байгууллагуудаас авдаг.

Гадаад худалдааны статистик мэдээллийн чанарыг дээшлүүлэхийн тулд гаалийн мэдүүлгээс гадна бусад эх сурвалжуудыг аль болох бүрэн дүүрэн ашиглах нь зүйтэй юм. Тухайлбал, зорчигч нь 1000 ам доллараас дотогш үнийн дүнтэй тэнцэх арилжааны чанартай бараанд гаалийн мэдүүлгээр бус хураамжийн хуудсаар гаалийн болон НӨТ-ийг төлж бараагаа улсын хилээр нэвтрүүлж байгаа. Үүргийн худалдаа гэж үзэж болох энэ хэсэг нь гадаад худалдааны статистикт төдийлөн хамрагдахгүй байгаа бөгөөд үүнийг хамруулахад тооцоо судалгаа шаардлагатай. Иймд мэдээний хамралтыг сайжруулах зорилгоор ядаж жилд нэг удаа уг төрлийн барааны талаар судалгааг хийж нэгтгэж гаргах нь зүйтэй байна.

Ингэснээр гадаад худалдааны статистикийн мэдээ олон улсын нийтлэг арга зүйд нийцэж, төлбөрийн тэнцэл болон үндэсний тооцооны дансууд, нөөц ашиглалтын хүснэгт байгуулах зэрэг ажлын чанар сайжрах билээ. Түүнчлэн макро эдийн засгийн түвшинд хийх судалгаа, шинжилгээ, бодлого боловсруулалтын үр дүнг дээшилнэ.

Гадаад худалдааны статистик нь барааны болон үйлчилгээний гэсэн 2 төрлөөс бүрдэнэ. Гадаад худалдааны үйлчилгээнд эдийн засгийн харъяат бусад үзүүлсэн үйлчилгээний орлогыг экспортод, эдийн засгийн харъяат бус байгууллагуудаар үйлчлүүлсний хөлсөнд төлсөн төлбөрийг импортод тусгаж байгаа юм.

Үйлчилгээний худалдааны үзүүлэлтүүдийг гаргах суурь мэдээлэл бол Монгол Улсын төлбөрийн тэнцэл юм. Үйлчилгээ гэдэг ухагдахуун нь биет бус бүтээгдэхүүн, үйл ажиллагааны нэр төрлийг хамарсан ойлголт юм. Дэлхийн олон оронд энэ ойлголт нь 1993 оны YTC-тэй уялдсан ойлголтоор хэрэглэгдэж байгаа бөгөөд төлбөрийн тэнцлийн мэдээнд тусгагдахдаа авч буй эх үүсвэрээрээ буюу өөрөөр хэлбэл үйлчилгээний экспорт, импортын мэдээллийг Төв банкнаас цуглуулж, харин барааны экспорт, импортын мэдээллийг гаалийн статистик мэдээллээс тус тус авч тусгадаг байна.

Үйлчилгээний худалдаа нь гадаад худалдааны үзүүлэлтэд шууд тусгагдахгүй, харин төлбөрийн тэнцлийн бүрэлдэхүүн хэсэг болдог олон улсын нийтлэг жишиг аргачлалтай. Иймээс энэ мэдээллийг төлбөрийн тэнцлийг эрхлэн боловсруулдаг Монголбанк хариуцах бөгөөд үйлчилгээний худалдааны статистик мэдээллийн хамралтыг сайжруулах үүднээс худалдааны статистикийн хамрах хүрээг сайжруулах, тооцох аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр Монгол банкнаас YCG-тай нягт хамтарч ажиллах шаардлагатай байгаа юм.

Гадаад худалдааны статистик судалгаанд хэрэглэгдэх аргуудыг өргөжүүлэх, боловсронгуй болгох. Өнөөгийн байдлаар гадаад худалдааны нийт эргэлт, экспорт, импортын үзүүлэлтүүдэд бүтцийн болон харьцангуй хэмжигдэхүүний судалгааг хийж байгаатай зэрэгцээ экспорт, импортын биет хэмжээсийн болон дундаж үнийн индексийг тооцож судалгаа дүгнэлт хийж байгаа ч цаашид дундаж үнийн индексийн тооцоог улам боловсронгуй болгох индексийн зарим аргын онцлог тооцоог ашиглах, Корреляцын шинжилгээ хийх зэргээр судалгааны аргачлалыг сайжруулах шаардлага гарч байгаа юм.

Индексийн аргын судалгааг өргөжүүлэх. Индексийн суурийг өөрчлөх, нэгтгэн уялдуулах, дутуу элементийг нөхөн тооцох аргыг судалгаанд өргөн ашиглан сурах нь чухал байна.

Практик үйл ажиллагааны явцад индексийн суурийг солих шаардлага цөөнгүй гардаг. Тодорхой нэг барааны хувьд индексийн суурийг солиход төвөггүй болдог юм.

Нэгтгэн уялдуулах. Индексийг нэг сууриас нөгөө суурьт шилжүүлэхийн зэрэгцээ хоёр өөр үеэр суурилсан нэг төрлийн үзүүлэлтийн индексийг нэгтгэн нэг динамик өсөлтийг харуулах хэрэгцээ тохиолддог. Ийм тооцоо хийх арга нь үндсэндээ суурь шилжүүлэхтэй ижил юм.

Олон нэр төрлийн барааны үнийн дундаж өөрчлөлтийг тусгасан агрегат индексийн хувьд энэ аргыг хэрэглэхэд үр дүн нь эх материалыг ашиглах шууд тооцсон индекстэй ойролцоо гарах боловч тэр бүр яг тохирохгүй.

Дутуу элементийг нөхөн тооцох. Индексийг тооцоход шаардагдах зарим элемент аль нэг үе хугацаанд байхгүй үед индексийг тооцох талаар нэг жишээ авч үзье. 1980-1997 онд дөрвөн бүлэг барааны үнэ дунджаар яаж өөрчлөгдсөнийг тооцох шаардлагатай байтал "а" барааны үнэ 1997 онд мэдэгдэхгүй байлаа.

	а		б		в		г	
	р	q	р	q	р	q	р	Q
1980	12.0	5100	2000.0	200	7500.0	100	20.0	800
1995	13.5	6500	1400.0	350	7000.0	200	16.0	1000
1997	-	6800	1250.0	380	6000.0	220	15.0	1200

Энэ үед юуны өмнө үнэ нь мэдэгдэхгүй байгаа "а" барааг оролцуулахгүйгээр туслах чанарын индексийг дараах байдлаар тооцно.

$$I'_{P_{85/70}} = \frac{1400 \times 350 + 7000 \times 200 + 16 \times 1000}{2000 \times 380 + 7500 \times 200 + 20 \times 1000} = \frac{1906000}{2220000} = 85.86$$

$$I'_{P_{87/70}} = \frac{1250 \times 380 + 6000 \times 220 + 15.0 \times 1200}{2000 \times 380 + 7500 \times 220 + 20 \times 1200} = \frac{1813000}{2434000} = 74.47$$

Хэрэв:

$$\frac{I_{P_{87/70}}}{I_{P_{85/70}}} = \frac{I'_{P_{87/70}}}{I'_{P_{85/70}}}$$

гэсэн харьцаатай байна гэж үзвэл 1980-1995 онд 4 барааны үнэ нийтдээ яаж өөрчлөгдсөнийг

$$I_{P_{87/70}} = \frac{I_{P_{85/70}} \times I'_{P_{87/70}}}{I'_{P_{85/70}}}$$

гэж тооцож болох юм. Бидний жишээгээр

$$I_{P_{85/70}} = \frac{1993750}{2298000} = 87.76 \text{ байх тул}$$

$$I_{P_{87/70}} = \frac{86.76 \times 74.47}{85.86} = 75.25 \text{ боллоо.}$$

Энэ аргыг зөвхөн ойролцоо тооцоо хийхэд ашиглах л боломжтой юм.

Корреляцын шинжилгээ хийх. Корреляцын шинжилгээ нь дараахь үе шатаар хийгдэнэ.

1. Тоон материалуудыг боловсруулж хамаарлыг илрүүлж, түүний хэлбэрийг тогтоох
2. Хамаарлын хүч, түүний нягтралыг корреляцын коэффициент, детерминацын коэффициент зэрэг үзүүлэлтээр хэмжиж, уг хамаарал функциональ хамааралтай хир ойр байгааг тооцох

Нэг ба олон хүчин зүйлийн корреляц, регрессийн шинжилгээг статистикийн багц программуудыг тооцож байна. Excel дээр нэг ба олон хүчин зүйлийн корреляц, регрессийг хэрхэн бодуулах талаар жишээ авч үзье.

Y - нийт хураасан ургац

X_1 - тариалсан талбай

X_2 - га-гийн ургац, ц (хүчин зүйлийн утга)

1) Excel дээр Insert/Function... ороход Paste Function гэсэн цонх гарна. Уг цонхноос функцийг CORREL гэж сонгоно. Ингээд Y, X_1 -ийн мужлан array 1,2-т зааж өгөхөд тухайн курсор байгаа нүдэнд тухайн Y, X_1 гэсэн хоёр үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг харуулсан корреляцын коэффициентын утга гарна. Жишээ болгон Y - нийт хураан авсан ургац, X_1 - тариалсан талбай авъя.

CORREL		X ✓ =		=CORREL(B1:B8,C1:C8)				
	A	B	C	D	E	F	G	H
1		y	x1	x2				
2	1990	718.3	787.7	11				
3	1992	493.9	657.7	8.3				
4	1993	479.5	584.8	8.8				
5	1994	330.7	470.6	7.4				
6	1995	261.4	372.6	7.3				
7	1996	220.1	347.8	6.6				
8	1997	240.4	333.9	7.6				
9								
10								
11								
12								
13								
14								
15								
16								
17								
18								
19								

CORREL	
Array1	B1:B8 = {0;718.3;493.9;479.5;330.7;261.4;220.1;240.4}
Array2	C1:C8 = {"x1";787.7;657.7;584.8;470.6;372.6;347.8;333.9}
= 0.985551323	
Returns the correlation coefficient between two data sets.	
Array2 is a second cell range of values. The values should be numbers, names, arrays, or references that contain numbers.	
Formula result	=0.985551323
OK	Cancel

$R=0.9855$ гарч байгаа нь тариалсан талбайн хэмжээнээс хураасан ургацын хэмжээ шууд хамааралтай болох нь харагдаж байна.

2) Хоёрдугаар тохиолдолд олон хүчин зүйлийн регрессийг бодуулая. Excel дээр Tools/Data Analysis... ороход цонх гарна. REGRESSION гэж сонгоход мөн цонх гарч ирнэ. Уг цонхны Input Y range хэсэгт үр дүнгийн утга буюу Y-ийн утгын мужаа өгнө. Input X range хэсэгт $X_1, X_2, \dots$ -ийн утгуудыг мужлан заана. Харин гарах үр дүнгийн утгуудын талбайг Output range хэсэгт зааж өгнө. Манай тохиолдолд $Y=aX+b$ хэлбэрийн шугаман регрессийг бодно.

Регрессийн тэгшитгэлийг бичвэл:

$$Y = 0.68710697 X_1 + 42.8900285 X_2 - 308.073523 \text{ болно}$$

Үндэсний тооцооны зарим дансны мэдээлэлд тулгуурлан гадаад худалдааны үйл ажиллагаанд хийх судалгааны чиглэл. Статистикийн аливаа ажлын эцсийн зорилго, үр дүн нь эдийн засгийн судалгаа бөгөөд Үндэсний тооцооны системд шилжсэнээр судалгааны бололцоо нөхцөл ч зарим талаар нэмэгдэж байгаа юм.

Үндэсний тооцооны системд дотоод эдийн засгийн дансуудаар дотоод зах зээл дээрх эргэлтийг бүрэн циклээх нь харуулдаг хэдий ч эдийн засгийн гадаад харилцааны үр дүнгүүдийг, тухайлбал, гадаад худалдаа, материаллаг бус үйлчилгээ, гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламж зэрэг үзүүлэлтүүдийг Төлбөрийн ихтэй нийцүүлсэн үзүүлэлтийн системийн иүвшинд Эдийн засгийн гадаад харилцааны дансаар тусад нь тооцдог.

Эдийн засгийн гадаад харилцааны дансны үзүүлэлтүүд нь төлбөрийн балансынхтай адил гадаад худалдааны эргэлт, валютын оролт, гаралт, гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг хамардаг хэдий ч дансны бүтэц нь үндэсний тооцооны дансынхтай нийцэрсэн байдаг. Тухайлбал, Эдийн засгийн гадаад харилцааны дансны орлого, хөрөнгийн болон санхүүгийн, мөн активуудын өөрчлөлт, актив, пассивын дансууд нь дотоод эдийн засгийн данснуудынхтай бүтэц, үзүүлэлтүүдийн агуулга нь ижил юм.

Эдийн засгийн гадаад харилцааны данс нь дараах суб дансуудаас бүрдэнэ.

- 1 Бараа үйлчилгээний данс
- 2 Анхны орлого, урсгал шилжүүлгийн данс
- 3 Хөрөнгийн данс
- 4 Санхүүгийн данс

5 Актив, пассивын данс

Эдгээр 5 данснаас Бараа, үйлчилгээний бусад нь үүний өмнө дотоод эдийн засгийн дансуудад давхар бичилт хийгдсэн дансууд байгаа болно. Дансуудын загварыг данс бүрээр хураангуйгаар харуулбал:

Бараа, үйлчилгээний данс

Ашиглалт	Нөөц
Бараа үйлчилгээний экспорт (P 6)	Бараа үйлчилгээний импорт (P 7)
-Барааны экспорт (P 6.1)	Барааны импорт (P 7.1)
-Үйлчилгээний экспорт (P 6.2)	Үйлчилгээний импорт (P 7.2)
Гадаад худалдааны сальдо (B1.1) (+,-)	

Эдийн засгийн гадаад харилцааны дансны суб данс (дэд данс) болох Бараа, үйлчилгээний дансаар тооцох үзүүлэлтүүд нь Төлбөрийн балансын гадаад худалдааны орлого, зарлагын баланст тусгадаг барааны экспорт, импорт, мөн аялал жуулчлал, даатгал, тээвэр, харилцаа холбоо зэрэг үйлчилгээний экспор, импортын юм. Гэвч эдгээр 2 данс, балансаар тооцох үзүүлэлтүүдийг нь эдийн засгийн үнэлэмжийн хувьд хооронд нь импортоор оруулж ирсэн барааг үндэсний валютаар (СИФ үнээр) харуулдаг бол Төлбөрийн балансын зарлагад импортын бараа худалдаж авсан чөлөөт валютын зарлагыг, харин Бараа, үйлчилгээний дансны ашиглалт талд гадаад зах зээлд гаргасан экспортыг үндэсний валютаар (ФОВ үнээр), Төлбөрийн балансын орлогод экспортын барааны чөлөөт валютын орлогыг тус тус бичдэг. Үүнээс үзвэл зарчмын гол ялгаа нь Эдийн засгийн гадаад харилцааны дансанд гадаад худалдааг оруулсан болон гаргасан барааны гадаад зах зээлийн үнээр тусгадаг байхад Төлбөрийн балансад гадаад худалдаанаас олсон болон зарцуулсан чөлөөт валютын орлого, зарлагыг харуулдаг. Үүний зэрэгцээ гадаад худалдаанд ашигтай, эсвэл алдагдалтай байснаас шалтгаалж сальдо нь Төлбөрийн балансын орлого, зарлагын аль ч талд байж болно. Харин үндэсний тооцооны дансны гол онцлог нь сальдотой адилтгах баланслуулах үзүүлэлтийг заавал дансны ашиглалт талд зохих тэмдгээр нь ялгаж байрлуулна. Энэ зарчмын дагуу Эдийн засгийн гадаад харилцааны дансны сальдог ашиглалт талд тусгана. Бараа, үйлчилгээний дансны ашиглалтад тусгасан, Гадаад худалдааны сальдо, нь дараагийн суб дансны нөөц талд шилжинэ.

Анхны орлого, урсгал шилжүүлгийн данс

Ашиглалт	Нөөц
-	Гадаад худалдааны сальдо (+,-) (B1.1)
Хөлсний ажиллагчдын хөдөлмөрийн хөлс (D1)	Хөлсний ажиллагчдын мөрийн хөлс (D1e)
Шууд бус татвар (татаас хассан) (D2-3)	Шууд бус татвар (татаас хассан) (D2-3)
Өмчийн орлого (D4)	Өмчийн орлого (D4)
Орлогын ба өмчийн татвар (D5)	Орлогын ба өмчийн татвар (D5)

Нийгмийн даатгалын шимтгэл, тусламж (D6)	Нийгмийн даатгалын шимтгэл, тусламж (D6)
Бусад урсгал шилжүүлгүүд (D7)	Бусад урсгал шилжүүлгүүд (D7)
Гадаад урсгал гүйлгээний сальдо (B1.2)	

Энэ дансны нөөц ба ашиглалтын үзүүлэлтүүдийн мэдээллийн эх үүсвэр нь Төлбөрийн балансын үйлчилгээний орлого, зарлагын тэнцлийн холбогдох үзүүлэлтүүд юм. Тухайлбал, нөөцийн үзүүлэлтүүдийг Төлбөрийн балансын орлогын хэсгээс, ашиглалтынхыг мөн балансын зарлага талаас авна. Анхны орлого, урсгал шилжүүлгийн дансны үзүүлэлтүүд, тэдгээрийн эдийн засгийн агуулга нь үндэсний тооцооны дансуудаас анхны орлогын хуваарилалтын дансынхтай ижил юм. Тухайлбал, үзүүлэлтүүдийг нь ч орлого хуваарилалтын дансны үзүүлэлтийн кодоор тэмдэглэсэн болно. Ер нь эдийн засгийн гадаад харилцааны дансны шилжих үлдэгдлээс бусад үзүүлэлтүүд нь эдийн засгийн агуулгын хувьд дотоод эдийн засгийн дансуудынхаар тодорхойлогдоно. Иймээс эдийн засгийн гадаад харилцааны тодорхой кодоор давхар тэмдэглэгдсэн болно. Бид эдийн засгийн гадаад харилцааны дансны өмнө дотоод эдийн засгийн дансанд орсон үзүүлэлтүүдийн агуулга, бүтцийн талаар дахин авч үзэхгүй бөгөөд зөвхөн шинэ үзүүлэлтүүдийн агуулгыг тайлбарлана. Анхны орлого, урсгал шилжүүлгийн дансны үзүүлэлтүүд нь, Эдийн засгийн гадаад харилцааны сектор, гэсэн баганаар дотоод эдийн засгийн, Анхны орлогын хуваарилалт, дансны нөөц ба ашиглалт талд иусгагдсан болно. Гэвч эдийн засгийн гадаад харилцааны дансны тодорхой үзүүдэдтүүдээс тусгалаа олж байгаа аливаа орлого, хөрөнгө нь эдийн засгийн ерөнхий агуулгын хувьд, тухайлбал, цалин, хувьцааны ноогдол ашиг, зээлийн хүү гэх мэт утгаараа дотоод эдийн засгийн дансны холбогдох үзүүлэлтүүдийнхтэй адил хэдий ч дурьдсан орлого, хөрөнгө эдийн засгийн харъяаллын талаасаа хэнийх болохын хувьд дотоод эдийн засгийн дансуудынхаас зарчмын ялгаатай. Эдгээр 2 бүлэг дансны нол ялгаа нь **эдийн засгийн харьяат** болон **эдийн засгийн харьяат бусын** гэсэн өмчлөлийн статусын байдлаар тодорхойлогдоно. Нийтлэг агуулгын хувьд орлогын дансны нөөц нь гадаад зах зээлээс олсон эдийн засгийн харьяатуудын (гадаад оронд ажиллагчдын алин хөлс, хувьцааны ноогдол ашиг гэх мэт) орлого, ашиглалт талд эдийн засгийн харьяат бусын манай эдийн нутаг дэвсгэр дээрээс олсон орлого байдаг. Иймээс Анхны орлого, урсгал шилжүүлгийн дансны балансуулах үзүүлэлт болох, Гадаад урсгал гүйлгээний сальдо, нь эдийн засгийн харьяатын гадаадаас оруулсан орлого ба эдийн засгийн харьяат бусын гадаадад гаргасан орлогын зөрүү юм.

Хөрөнгийн данс

Ашиглалт	Нөөц
Санхүүгийн биш үйлдвэрлэгдээгүй активыг худалдан авсан өртөг (K2)	Гадаад урсгал гүйлгээний сальдо (B1.2)
	Гадаадаас авсан капитал шилжүүлгүүд (+d9)
	Гадаадад гаргасан капитал шилжүүлгүүд (-d9)
	Хадгалаж ба капитал шилжүүлгээр бий болсон капиталын цэвэр өртөг (B1.2+d9-96)
Цэвэр зээлжүүлэлт (+), Цэвэр өглөг (-)	

Эдийн засгийн гадаад харилцааны суб данс-Хөрөнгийн данс нь дотоод эдийн засгийн Хөрөнгийн данснаас нэлээд өөр юм. Дотоод эдийн засгийн Хөрөнгийн дансаар эдийн засгийн секторууд өөрсдийн мөнгөн хуримтлал (хадгаламж) болон үндсэн хөрөнгийн элэгдлийн шимтгэл, мөн капитал шилжүүлгийн (хөрөнгө оруулалт, өмчлөх эрх шилжих г.м) эх үүсвэрээр үндсэн ба эргэлтийн хөрөнгө, үнэт зүйл, түүнчлэн газар, газрын баялаг зэрэг үйлдвэрлэгдээгүй капиталын хуримтлалыг санхүүгийн ямар үр дүнтэйгээр (цэвэр зээлжүүлэлт, эсвэл цэвэр өглөгтэйгээр) бий болгосныг харуулдгийг бид мэднэ. Харин эдийн засгийн гадаад харилцааны дансны нөхцөлд Хөрөнгийн дансаар эдийн засгийн харъяат болон дийн засгийн харъяат бусын хооронд хөрөнгө шилжих ба худалдах, худалдан авах ажиллагааны үр дүнд хөрөнгийн хуримтлал бий болохыг харуулна. Хөрөнгийн дансны нөөц талын эх үүсвэр нь урсгал орлогын данснаас шилжиж ирсэн гадаад урсгал гүйлгээний сальдо, гадаадаас авсан болон гаргасан капитал шилжүүлгийн зөрүүгийн нийлбэр буюу хадгаламж ба капитал шилжүүлгийн дүнд бий болсон капиталын цэвэр өртөг юм. Эдгээр эх үүсвэрээс уг дансны ашиглалт талд тусгасан эдийн засгийн харъяат бусад худалдсан үйлдвэрлэгдээгүй активын (газар худалдах) өртгийг хасч цэвэр зээлжүүлэлт (+), эсвэл цэвэр өглөг (-) тооцож, дансны үр дүнг гаргана. Үр дүнгийн энэ 2 үзүүлэлтийн эдийн засгийн утга нь дотоод эдийн засгийн хөрөнгийн дансны мөн үзүүлэлтүүдийнхтэй адил юм.

Актив, пассивын данс

Эдийн засгийн гадаад харилцааны данснуудын гүйлгээний төгсгөлийн буюу үр дүнгийн данс нь Актив, пассивын данс бөгөөд энэ данс нь дотоод эдийн засгийн Актив, пассивын дансны нэгэн адил эхний баланс, жилийн туршид гарсан өөрчлөлт, эцсийн баланс гэсэн үзүүлэлтийн хувьд адил 3 хэсгээс бүрддэг. Балансын ерөнхий бүтцийг харуулбал:

Активууд	Пассивууд ба капиталын цэвэр өртөг
Санхүүгийн бус активууд (AN)	Пассивууд (AF)
Үйлдвэрлэгдээгүй активууд (AN2)	
Санхүүгийн активууд (AF)	
	Капиталын цэвэр өртөг (B)

Эдийн засгийн гадаад харилцааны дансын актив, пассивын гүйлгээ нь үндсэндээ санхүүгийн активуудад хамаарна. Бараа, үйчилгээний данс, Анхны орлого, урсгал, шилжүүлгүүдийн данс, Хөрөнгө санхүү, Бусад активуудын өөрчлөлтийн данснуудын актив, пассивын үр дүнг нэгтгэж, энэ дансаар харуулна. Хэрэв уг дансны актив тал нь хасах тэмдэгтэй байвал гадаад эргэлтэд тухайн улс өглөгтэй байх бөгөөд эерэг бол улсын дүнгээр авлагарай гарна. Актив, пассивын данс нь эцсийн дүндээ хөрөнгийн үр дүнг харуулдаг тул энэ зорилгоор уг дансны активд тухайн орны нийт санхүүгийн бус актив, үүнээс үйлдвэрлэгдээгүй активыг гадаад эргэлтэд хамаарах санхүүгийн активтай хамт харуулдаг нь нийт эдийн засгийн хэмжээнд капиталын цэвэр өртгийн хэмжээг үзүүлэх боломжтой болох юм. Энэ үзүүлэлт нь нийт активын дүнгээс пассивыг хасч, пассивд тэнцэл хэлбэрээр тооцогдоно.

Одоогоор ҮСГ-аас дээрх дансуудын эхний 2 дансыг туршилтын журмаар байгуулаад байна. Цаашид дээрх дансуудыг бүрэн хэмжээгээр байгуулж судалгаа дүгнэлт хийх нь гадаад худалдааны статистик судалгааны шинэ чиглэл байх болно.

Судалгааны тайлангийн бүтцийг сайжруулах. Статистикч хүний ажлыг судалгааны тайлангүйгээр бүрэн гүйцэд болсон гэж үзэж болохгүй юм. Энэ нь хамгийн эцсийн шат бөгөөд судлаачийн хийсэн ажлыг бусад хүмүүс хэрхэн хүлээж авах, үнэлэх нь эндээс шалтгаална. Гадаад худалдааны судалгааны тайлангийн ерөнхий бүтэц нь дараах хэлбэртэй байх нь зүйтэй байна.

1. Оршил. Тухайн судлах зүйлийн дүр төрх, судалгааны ажлын зорилго, шийдвэрлэхээр тавьсан асуудлуудыг энд оруулж өгнө.
2. Үзэл баримтлал, тодорхойлолтууд. Судалгааны далайц, хамрах хүрээ, арга аргачлал, ангилал, үзүүлэлтүүдийн тодорхойлолтыг авч үзнэ.
3. Судалгааны үйл явц. Судалгааны дизайн, түүврийн төрөл, хэмжээ, мэдээлэл цуглуулах болон боловсуулах явц, түүнд ашигласан статистик шижилгээний арга техник, тоо мэдээнийхээ чанар, хэмжээ хязгаарыг энд тодорхойлно.

4. Үр дүн. Судалгааны үр дүн бол судалгааны ажлын хамгийн гол үндсэн хэсэг юм. Гарсан үр дүнгээ харьцуулах, хүснэгт, графикаар харуулах, гол гол тайлбарыг хийнэ.
5. Дүгнэлт.
 1. Судалгааны ажлын эхэнд тавьсан зорилго, асуудлуудынхаа үр дүнг нэгтгэн танилцуулж, түүний үндсэн дээр хэрэгжүүлэх бодлогын чанартай санал, зөвлөмж, дүгнэлтийг бичнэ.
 2. Өөрийн саналаа бичих. Та энэ ажлаараа хэлэхийг хүссэн боловч тоо мэдээ болон цаг хугацаанаас хамаарч хийж амжаагүй зүйлс, түүний шалтгааныг ч бичиж болох юм.
 3. Энэ сэдвээр цаашид судалгаа хийх судлаачдад зориулж санал, зөвлөмжөө бичих хэрэгтэй. Шаардлагатай хүснэгт, тооцоо, мэдээллийг хавсаргах
6. Хавсралтууд. Шаардлагатай хүснэгт, тооцоо мэдээллийг хавсаргах
7. Ашигласан ном, жагсаалт. Ашигласан номын жагсаалтыг зохиогчийн болон бүтээлийн нэр, хэзээ хаана хэвлэгдсэн г.м товч тодорхой хийж хавсаргана.

Эцэст нь энэхүү судалгааг хэн, хэзээ хийснийг бичих хэрэгтэй.

Үр дүнгийн тайлан нь судалгааны ажлаас гарч буй эцсийн бүтээгдэхүүн юм. Судалгааны тайлан нь тухайн судалгааны ажил хэрхэн явагдсан, ямар туршлага, нөөцийг амжилттай ашигласан, бүхий л явцыг харуулдаг. Сайн системтэй бичигдсэн тайлан нь цаашид хийгдэх судалгаанудад ашиглахад ач холбогдолтой байдаг.

Ашигласан материал

1. System of national accounts, 1993, UN8 WB, IMF, OECD
2. Адамов В.Е "Факторный индексный анализ и статистика" 1977
3. International Merchandise Trade Statistics: Concepts and Definitions, UNSD, 1998
4. Г.Оросоо. Үндэсний Тооцооны данс, салбар хоорондын баланс, 2002 он
5. Б.Машир. Эдийн засгийн судалгаанд индексийн аргыг хэрэглэх нь, УБ, 1995 он
6. Орон нутгийн статистик судалгаа хийх арга зүйн зөвлөмж, ҮСГ, 1996 он